



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 9/445

Мандалговь

Г  
Мандал шилтгээн ХХК-тай нэмэлт  
гэрээ байгуулах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 34 дугаар зүйлийн 34.2, 34.1.4 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


Нэг. Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх “Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын тохижилт, ногоон байгууламж (Сайнцагаан сум)” ажлын гүйцэтгэгч “Мандал шилтгээн” ХХК-тай байгуулсан ЗТХЯ/201901022-ны дугаартай 278,837,136 (Хоёр зуун далан найман сая найман зуун гучин долоо мянга нэг зуун гучин зургаан төгрөг) төгрөгийн дүнг 20,954,299 (хорин сая есөн зуун тавин дөрвөн мянга хоёр зуун ерэн ес) төгрөгөөр нэмэлт гэрээ байгуулсугай.

Хоёр. Нэмэлт батлагдсан зураг төсвийн дагуу “Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын тохижилт, ногоон байгууламж (Сайнцагаан сум)” ажлыг чанартай хийж гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Мандал шилтгээн” ХХК-ны захирал (Б.Ням)-д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай нэмэлт гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Эрдэнсүрэн), Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Э.Чагнаадорж), Сайнцагаан сумын Засаг дарга (Р.Мөнхтогтох), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (А.Ганбат)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ



488191253